

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/10/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт	3
Хүснэгтийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Залруулсан алдаа	20
5.2 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.....	15
Хүснэгт 2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	16
Хүснэгт 3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 4 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт	17
Хүснэгт 5 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	19

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/71
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь удирдах ажилтны зөвлөгөөнд оролцогсдод 1,740.0 мянган төгрөгийн хүлээн авалт хийсэн, ЭМГ-ын даргын 2022 оны А/20 дугаарын тушаалаар хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулахтай холбогдуулан зохион байгуулсан сургалтад оролцогч нарт 1,428.0 мянган төгрөгийн гарын бэлэг өгсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторов мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- 2021 оны санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдэлгүй Ган судар ХХК руу 2021 оны zoom виртуал программын эрх гэж 900.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

G/Arkhir/Alban bichig 2023/ A4

19020098

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,041,332,125.6	1,293,412,226.4
33	АВЛАГА	5,000,000.0	0.0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,000,000.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	1,036,332,125.6	1,293,412,226.4
351	Түүхий эд материал	762,153,912.5	503,988,689.5
35110	Тусгай зориулалттай материал	2,295,700.0	2,295,700.0
35130	Эм боох материал	759,858,212.5	501,692,989.5
354	Хангамжийн материал	274,178,213.1	789,423,536.9
35410	Бичиг хэргийн материал	2,312,375.0	2,341,554.0
35420	Аж ахуйн материал	917,550.0	1,163,550.0
35440	Түлш, шатах тослох материал	10,434,405.0	3,878,987.0
35450	Барилгын засварын материал	5,009,700.0	5,009,700.0
35470	Бусад хангамжийн материал	255,504,183.1	777,029,745.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	916,121,037.1	853,989,289.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	916,121,037.1	853,989,289.3
392	Биет хөрөнгө	757,669,637.4	695,597,889.3
39201	Барилга, байгууламж, орон сууц	618,815,865.6	618,815,865.6
39202	Хуримтлагдсан элэгдэл	-69,100,752.4	-92,123,197.2
39203	Авто-тээврийн хэрэгсэл	276,851,297.0	276,851,297.0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	257,766,438.9	263,751,497.6
39206	Хуримтлагдсан элэгдэл	-190,195,401.6	-200,105,044.7
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	101,837,591.1	101,837,591.1
39208	Хуримтлагдсан элэгдэл	-81,898,985.3	-88,228,347.2
393	Биет бус хөрөнгө	158,451,399.7	158,391,400.0
39301	Програм хангамж	2,057,500.0	2,057,500.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,997,500.3	-2,057,500.0
39303	Бусад биет бус хөрөнгө	158,391,400.0	158,391,400.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,957,453,162.8	2,147,401,515.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,957,453,162.8	2,147,401,515.7
51	Засгийн газрын хувь оролцоо	1,957,453,162.8	2,147,401,515.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,142,232,871.8	1,142,232,871.8
51101	Өмч: - төрийн	983,841,471.8	983,841,471.8
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	158,391,400.0	158,391,400.0
512	Хуримтлагдсан үр дүн	575,912,817.0	765,861,169.9
51210	Өмнөх үеийн үр дүн	575,912,817.0	575,912,817.0
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	189,948,352.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	239,307,474.0	239,307,474.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,957,453,162.8	2,147,401,515.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,842,936,314.9	4,413,705,586.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,541,294,123.0	2,083,846,360.0
120	Нийтлэг татварын бус орлого	7,541,294,123.0	2,083,846,360.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,301,642,192.0	2,329,859,226.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,573,503,800.0	2,227,692,900.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,573,503,800.0	2,227,692,900.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,728,138,392.0	102,166,326.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	181,568,850.0	38,994,402.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	198,768,342.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,317,845,700.0	61,098,924.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,955,500.0	2,073,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,357,680,080.6	2,686,682,149.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,357,680,080.6	2,686,682,149.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,384,314,112.2	1,337,830,317.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,028,368.6	565,501,764.0
210101	Үндсэн цалин	346,519,221.9	351,696,366.0
210102	Нэмэгдэл	146,478,575.0	95,835,069.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,060,000.0	40,545,000.0
210104	Урамшуулал	34,970,571.7	77,425,329.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,406,929.0	73,566,269.5
210201	Тэтгэврийн даатгал	54,865,480.0	50,993,831.9
210202	Тэтгэмжийн даатгал	5,465,455.2	5,872,227.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,355,684.2	4,556,661.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,065,491.8	1,103,958.6
210205	Эрүүл мэндийн даатгал	10,654,817.8	11,039,590.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,896,730.0	84,081,222.0
210301	Гэрэл, цахилгаан	6,735,994.0	6,029,413.0
210302	Түлш, халаалт	67,480,248.0	68,072,136.0
210303	Цэвэр, бохир ус	5,680,488.0	9,979,673.0
2104	Хангамж, бараа материалын зардал	76,524,366.0	350,717,175.8
210401	Бичиг хэрэг	7,184,550.0	7,416,681.0
210402	Тээвэр, шатахуун	52,721,440.0	53,269,970.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,492,053.0	8,886,786.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.0	480,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,646,323.0	5,417,220.0

210408	Бараа материал акталсны зардал	0.0	275,246,518.8
2105	Нормативт зардал	171,797,668.4	21,726,260.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	171,797,668.4	21,726,260.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	95,069,531.6	39,395,289.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	82,272,971.6	5,947,619.0
210604	Урсгал засвар	12,796,560.0	33,447,670.0
2107	Томилолт, зочны зардал	33,554,400.0	37,612,700.0
210702	Дотоод албан томилолт	33,554,400.0	37,612,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,523,765.0	11,287,978.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,493,345.0	3,180,465.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,220,000.0	2,220,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.0	1,500,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	188,320.0	350,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.0	99,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,661,100.0	3,512,000.0
210807	Газрын төлбөр	351,000.0	426,513.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	264,512,353.6	153,941,658.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	189,412,576.0	78,708,302.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,520,000.0	7,116,550.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,579,777.6	68,116,806.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,973,365,968.4	1,348,851,832.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,962,467,300.0	1,305,752,503.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,217,400,000.0	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	827,739,500.0	416,227,900.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	862,547,800.0	886,026,703.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,780,000.0	3,497,900.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,898,668.4	0.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,898,668.4	0.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.0	43,099,329.5
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	43,099,329.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,485,256,234.4	1,727,023,436.5
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,781,535,900.5	1,537,075,083.6
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,218,269.2	0.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-6,781,535,900.5	-1,537,075,083.6
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	703,720,333.9	189,948,352.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,303,792,192.0	2,334,859,226.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,303,792,192.0	2,334,859,226.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,573,503,800.0	2,227,692,900.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,573,503,800.0	2,227,692,900.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,730,288,392.0	107,166,326.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	181,568,850.0	38,994,402.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	198,768,342.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,317,845,700.0	61,098,924.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,105,500.0	7,073,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,291,823,192.0	2,334,859,226.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,291,823,192.0	2,334,859,226.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,313,457,223.6	986,007,393.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,028,368.6	565,501,764.0
210101	Үндсэн цалин	346,519,221.9	351,696,366.0
210102	Нэмэгдэл	146,478,575.0	95,835,074.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,060,000.0	40,544,998.4
210104	Урамшуулал	34,970,571.7	77,425,325.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,406,929.0	73,566,269.5
210201	Тэтгэврийн даатгал	54,865,480.1	50,993,831.9
210202	Тэтгэмжийн даатгал	5,465,455.2	5,872,227.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,355,684.2	4,556,661.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,065,491.8	1,103,958.6
210205	Эрүүл мэндийн даатгал	10,654,817.8	11,039,590.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,896,730.0	84,081,222.0
210301	Гэрэл, цахилгаан	6,735,994.0	6,029,413.0
210302	Түлш, халаалт	67,480,248.0	68,072,136.0
210303	Цэвэр, бохир ус	5,680,488.0	9,979,673.0
2104	Хангамж, бараа материалын зардал	71,068,566.0	63,889,526.0
210401	Бичиг хэрэг	6,344,400.0	5,773,500.0
210402	Тээвэр, шатахуун	52,261,945.0	41,577,900.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,035,190.0	8,886,786.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.0	480,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,947,031.0	7,171,340.0
2105	Нормативт зардал	150,035,902.0	20,435,300.0

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	147,931,902.0	18,404,900.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,104,000.0	2,030,400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,001,600.0	31,724,370.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,043,000.0	2,315,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708,600.0	2,401,070.0
210604	Урсгал засвар	11,250,000.0	27,008,300.0
2107	Томилолт, зочны зардал	33,554,400.0	37,612,700.0
210702	Дотоод албан томилолт	33,554,400.0	37,612,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,583,765.0	12,063,678.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,343,345.0	3,255,978.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,220,000.0	2,220,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.0	1,500,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	188,320.0	350,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.0	99,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,871,100.0	4,287,700.0
210807	Газрын төлбөр	351,000.0	351,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	299,880,963.0	97,132,564.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	292,040,963.0	89,696,014.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,840,000.0	7,436,550.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,978,365,968.4	1,348,851,832.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,962,467,300.0	1,305,752,503.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,217,400,000.0	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	827,739,500.0	416,227,900.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	862,547,800.0	886,026,703.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,780,000.0	3,497,900.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,898,668.4	43,099,329.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,898,668.4	0.0
213304	Хөрөнгийн	0.0	43,099,329.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,969,000.0	0.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,969,000.0	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,969,000.0	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	11,969,000.0	0.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,969,000.0	0.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,097,766,471.8	240,639,297.2	(326,793,099.1)	1,011,612,670.0
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,097,766,471.8	240,639,297.2	(326,793,099.1)	1,011,612,670.0
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	122,427,914.0	122,427,914.0
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,142,232,871.8	239,307,474.0	575,912,817.0	1,957,453,162.8
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,142,232,871.8	239,307,474.0	575,912,817.0	1,957,453,162.8
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,142,232,871.8	239,307,474.0	575,912,817.0	1,957,453,162.8
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	189,948,352.9	189,948,352.9
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,142,232,871.8	239,307,474.0	765,861,169.9	2,147,401,515.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,229,693,000.0	2,184,593,570.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,229,693,000.0	2,184,593,570.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	923,138,300.0	880,341,067.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	592,189,700.0	565,501,764.0
210101	Үндсэн цалин	353,415,500.0	351,696,366.0
210102	Нэмэгдэл	119,066,900.0	95,835,074.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,045,000.0	40,544,998.4
210104	Урамшуулал	78,662,300.0	77,425,325.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,565,600.0	73,566,269.5
210201	Тэтгэврийн даатгал	57,398,000.0	50,993,831.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,041,900.0	5,872,227.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,833,500.0	4,556,661.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,208,400.0	1,103,958.6
210205	Эрүүл мэндийн даатгал	11,083,800.0	11,039,590.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,137,600.0	84,081,222.0
210301	Гэрэл, цахилгаан	6,353,700.0	6,029,413.0
210302	Түлш, халаалт	68,107,700.0	68,072,136.0
210303	Цэвэр, бохир ус	10,676,200.0	9,979,673.0
2104	Хангамж, бараа материалын зардал	59,202,900.0	55,979,626.0
210401	Бичиг хэрэг	5,441,700.0	5,441,500.0
210402	Тээвэр, шатахуун	37,292,700.0	34,000,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,608,200.0	8,886,786.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	482,800.0	480,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,377,500.0	7,171,340.0
2105	Нормативт зардал	20,435,300.0	20,435,300.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,404,900.0	18,404,900.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,030,400.0	2,030,400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,935,500.0	16,686,070.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,383,300.0	2,315,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,582,200.0	2,401,070.0
210604	Урсгал засвар	11,970,000.0	11,970,000.0
2107	Томилолт, зочны зардал	11,696,700.0	11,696,700.0
210702	Дотоод албан томилолт	11,696,700.0	11,696,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,605,800.0	12,063,678.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,275,800.0	3,255,978.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,570,000.0	2,220,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.0	1,500,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.0	350,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.0	99,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,438,000.0	4,287,700.0
210807	Газрын төлбөр	351,000.0	351,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,369,200.0	40,330,438.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,895,100.0	32,893,888.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,474,100.0	7,436,550.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,306,554,700.0	1,304,252,503.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,306,554,700.0	1,304,252,503.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	416,227,900.0	416,227,900.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	887,601,400.0	886,026,703.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,725,400.0	1,997,900.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,229,693,000.0	2,227,692,900.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,229,693,000.0	2,227,692,900.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,229,693,000.0	2,227,692,900.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	107,166,326.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	107,166,326.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,666,326.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,909,900.00
210401	Бичиг хэрэг	332,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,577,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,038,300.00
210604	Урсгал засвар	15,038,300.00
2107	Томилолт, зочны зардал	25,916,000.00
210702	Дотоод албан томилолт	25,916,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,802,126.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,802,126.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	107,166,326.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	107,166,326.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	38,994,402.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,098,924.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,073,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Урьдчилан сэргийлэх багцын үзлэг”-ийг аймаг орон нутагтаа мэргэжил арга зүйн удирдлагаар ханган зохион байгуулж хамрагдвал зохих 94,042 иргэнээс 23,225 иргэн буюу 24.7% хамруулан ажилласан байна.

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн талаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, бодлого, шийдвэр, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Улс, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн салбарын аймгийн хэмжээнд мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах, хүн амд эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ хүргэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ЭМС-ын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Эрүүл мэндийн салбарт 2022 онд 11.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянцогт, Баян-Өнжүүл, Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилга, 3 суманд барилгын өргөтгөл засвар, түргэн тусламжийн автомашин 16 суманд, Нэгдсэн эмнэлэг, өрх, 26 сумын Эрүүл мэндийн төвд 78 нэр төрлийн 265 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлж тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг нэмэгдүүлэн үйл ажиллагаагаа явуулсан байна.

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 бүлэг, 8 зорилт, 64 дэд зорилттой, хавсралт 1-ээр "Зохион байгуулах сургалтын төлөвлөгөө", хавсралт 2-оор "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө"-г баталсан байна. Жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээ тус байгууллага 64 ажлыг 100 хувьтай гүйцэтгэсэн гэж дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ээс шинээр мөрдөгдөж эхэлсэн,
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ээс шинээр мөрдөгдөж эхэлсэн,
- Эрүүл мэндийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22, 6 дугаар сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн а/54 дүгээр тушаалаар хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтнээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод аудитын багийг шинэчлэн томилсон. Мөн 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн а/64 дүгээр тушаалаар “Дотоод аудит хийх журам”-ыг батлан, мөрдөн ажиллаж байна.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын дотоод хяналтын багийн жилийн ажлын төлөвлөгөөг 4 зорилт, 9 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулсан ба төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг 100% хугацаанд нь хийсэн байна.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 189,948.4 мянган төгрөгөөр буюу 9,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	5,000.0	-	(5,000.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	1,036,332.1	1,293,412.2	257,080.1
Үндсэн хөрөнгө	916,121.0	853,989.3	(62,131.7)
Нийт хөрөнгө	1,957,453.2	2,147,401.5	189,948.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,957,453.2	2,147,401.5	189,948.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,957,453.2	2,147,401.5	189,948.4

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар татаас санхүүжилтийн 5,000.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг 100% барагдуулсан.

Бараа материал дансны хувьд бичиг хэргийн материал 29,179.0 мянган төгрөг, аж ахуйн материал 246,000.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 521,525,563.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, эм боох материал 258,165,223.0 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 6,555,418.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2022 онд үнэ төлбөргүй хүлээн авсан 5,985.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,147,402.0 мянган төгрөг болж 189,948.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,866,020.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2022 оны 1 дүгээр сард төсөв 2,268,144.9 мянган төгрөгөөр батлагдсан. Төрийн хэмнэлтийн хууль батлагдсан болон эрүүл мэндийн салбарт цалингийн төсөв өөрчлөгдсөнтэй холбоотой 2022 оны 7 дугаар сард төсөв 2,288,792.1 мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна. 2022 оны 12 дугаар сард байгууллагын төсөвт өөрчлөлт оруулах санал болон сайдын баталснаар 2022 оны нийт батлагдсан төсөв 2,229,693.0 мянган төгрөг болж буурсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээний хүрээнд улсын төсвөөс нийт 2,229,693.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,227,692.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. 45,099.5 мянган төгрөг зарцуулаагүй төвлөрүүлж, санхүүжилтээс хасагдах дүнгээр хоорондын тооцоонд тусгасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,184,593.6 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 33,687.3 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 1,056.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 3,223.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 249.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 542.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 4,038.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 2,302.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийн бодлого, удирдлага-Үндсэн үйл ажиллагааны зардал	904,162.2	862,405.9	41,756.3	95,4%

2	Эрүүл мэндийн бодлого, удирдлага - Ажил олгогчоос олгох тэтгэмж	18,976.1	17,935.1	1,041.0	94,5%
3	Эрүүл мэндийн бодлого, удирдлага - Хөтөлбөр төслийн дотоод урсгал	1,306,554.7	1,304,252.5	2,302.2	99,8%
	Дүн	2,229,693.0	2,184,593.5	45,099.5	98%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 61,098.9 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс буюу ДЭМБ, Монголын сумын эмч мэргэжилтний холбооноос 38,994.4 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгосон нэмэлт орлого 7,073.0 мянган төгрөг, нийт 107,166.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Эрүүл мэндийн газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар бичиг хэргийн зардалд 332.0 мянган төгрөг, тээвэр шатахуунд 7,577.9 мянган төгрөг, урсгал засварын зардалд 15,038.3 мянган төгрөг, дотоод албан томилолт 25,916.0 мянган төгрөг, бусад ажил үйлчилгээний зардалд 56,802.1 мянган төгрөг нийт 107,166.3 мянган төгрөг зарцуулжээ.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71603 80101	2022.01.01-2022.12.31	Үндсэн үйл ажиллагаа	Үндсэн үйл ажиллагаа 95,4	904,162.2	862,405.9
2	71603 80202	2022.01.01-2022.12.31	Ажил олгогчоос олгох тэтгэмж	Ажил олгогчоос олгох тэтгэмж 94,5	18,976.1	17,935.1
3	71603 83112	2022.01.01-2022.12.31	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	Хөтөлбөр төслийн дотоод урсгал 99,8	1,306,554.7	1,304,252.5

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын нийгмийн хамгааллын дэмжих хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдад тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмжийг гүйцэтгэлд суурилан санхүүжилтийн хүсэлтийг холбогдох материалын хамт албан бичгээр хүргүүлэн олгогдож байсантай холбоотой байна.

Хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлтийн олон нийтийн зард мэдээлэл хүргэн албан хаагчдыг сонгон шалгаруулалт хийж төрийн үйлчилгээний албан хаагчдын боловсон хүчний асуудлыг шийдвэрлэж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрүүл мэндийн газар 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 01/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт орлого 11,842,936.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 177,644.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 142,115.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь тайлант онд төсвийн хэмнэлтийн талаарх ЭМЯ-аас өгсөн чиглэлийн дагуу цалин хөлс, нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардлуудыг бууруулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 100 хувьтай, 5.0 саяас дээших орлогын 27 гүйлгээ, зарлагын 19 гүйлгээ, 5.0 саяас дээших худалдан авалттай холбоотой 1 гүйлгээг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд аудитын урьдчилсан болон төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэж, байгууллагын мөрдөж ажилладаг хууль тогтоомжийн хэрэгжилт, ирсэн явсан бичиг, даргын тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж эрсдэлээ тодорхойлсон.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 01/104 дугаарын албан бичгээр ирүүлсэн.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	6,000.0	1	6,000.0	100
Албан шаардлага	2	69,107.2	2	69,107.2	100
Зөвлөмж	1	5,610,696.7	1	5,610,696.7	100
Нийт дүн	4	5,685,803.9	4	5,685,803.9	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын түрээсийн орлого, хүнс, эмийн материалын зарцуулалтыг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 4,296.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

Тус байгууллага тайлант онд ХААН банк дахь харилцах дансны орлого, зарлагын 4,223.1 мянган төгрөгийг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Тайлант онд 1,474.5 мянган төгрөгийн өртөгтэй шинээр нэмэгдсэн 1 үндсэн хөрөнгөнд 73.3 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй байна. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Дансны заавар”-ын “Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэл”-ийн 4.35-д “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө.” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 367,687.3 мянган төгрөгийн илэрсэн зөрчилд² 316,838.1 мянган төгрөгийн зөвлөмж, 900.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 49,949.2 мянган төгрөгийн албан шаардлага өглөө.

5.2 Төлбөрийн акт

2021 оны санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдэлгүй Ган судар ХХК руу 2021 оны zoom виртуал программын эрх гэж 900.0 мянган төгрөг шилжүүлсэн зөрчил илэрлээ. Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

ДРЭАМДО АЙТИ ХХК-иас 2022 оны zoom виртуал програмын 1 жилийн эрхийг 1,297.0 мянган төгрөгөөр буюу бодит үнээс өндөр үнээр авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Хүүхдээ асарч буй эхийн чөлөөтэй байх хугацааны НДШ-ийг ажил олгогч төлж тайлагнаагүй зөрчилд нийгмийн даатгалын улсын байцаагчийн тавьсан актын алданги 288.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад эм боох материал 1,042.3 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,005.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Сургалтын үйл ажиллагаанд зориулан хэрэглэгдэхүүн худалдаж авахдаа харилцагч байгууллагаас 5,536.2 мянган төгрөгийн бараа материалыг дансанд орлого авалгүй зардал данс руу хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан

бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Дарга үүрэгт ажлаа хэрхэн биелүүлсэн хэдэн хувиар өгөх шийдвэр болон хаасан огноо байхгүй томилолтын хуудсаар 37,612.7 мянган төгрөгийн томилолт олгохдоо тухай бүр бүртгэлд тусгадаггүй олгох үедээ хувь хүмүүст өгөх өглөг дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Удирдах ажилтны зөвлөгөөнд оролцогсдод 1,740.0 мянган төгрөгийн хүлээн авалт хийсэн, ЭМГ-ын даргын 2022 оны 04 сарын 22-ны өдрийн А/20 дугаарын тушаалаар хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулахтай холбогдуулан зохион байгуулсан сургалтад оролцогч нарт 1,428.0 мянган төгрөгийн гарын бэлэг өгсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлин 15.1.3 “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 298,234.9 мянган төгрөгийн өртгөтэй 1190 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019

оны 271 дүгээр тогтоолын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгах, ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах.

2. *Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

2.1 Илрүүлэлт:

Төв ньюс ХХК-тай байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх зорилготой 2,400.0 мянган төгрөгийн гэрээг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр байгуулж 2,400.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дагаж мөрдөх, шаардлагатай мэдээ мэдээллийг Аймгийн Засаг даргын хэвэл мэдээллийн албаар дамжуулан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх

3. *Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

3.1 Илрүүлэлт:

Харилцагч байгууллагатай хийсэн 16,203.3 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн сангийн харилцах данснаас ХААН банкны 5721506169 дугаарын дансанд шилжүүлсэн гүйлгээг арилжааны банкны харилцах дансанд бүртгээгүй	1	4,223.1	1	4223.1			1	4223.1
Тайлант онд 1,474.5 мянган төгрөгийн өртөгтэй шинээр нэмэгдсэн 1 үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй байна.	1	73.3	1	73.3			1	73.3
Дүн	2	4,296.4	2	4,296.4	0	0.0	2	4,296.4

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
Харилцагч байгууллагатай хийсэн 16,203.3 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.	16,203.3	-	-	16,203.3
2021 оны санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдэлгүй Ган судар ХХК руу 2021 оны zoom виртуал программын эрх гэж 900.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.	900.0	900.0	-	-
ДРЭАМДО АЙТИ ХХК-иас 2022 оны zoom виртуал программын эрхийг бодит үнээс өндөр үнээр авсан байна.	1,297.0	-	1,297.0	-

Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад эм боох материал 1,042.3 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,005.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	2,047.3	-	2,047.3	-
Харилцагч байгууллага руу бараа материал худалдан авахаар шилжүүлсэн мөнгөн дүн орлогод авсан дүн зөрүүтэй	5,536.2	-	5,536.2	-
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 298,234.9 мянган төгрөгийн өртөгтэй 1190 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	298,234.9	-	-	298,234.9
Дарга үүрэгт ажлаа хэрхэн биелүүлсэн хэдэн хувиар өгөх шийдвэр болон хаасан огноо байхгүй томилолтын хуудсаар томилолт олгохдоо тухай бүр бүртгэлд тусгадаггүй олгох үедээ хувь хүмүүст өгөх өглөг дансанд бүртгэсэн байна.	37,612.7	-	37,612.7	-
Удирдах ажилтны зөвлөгөөнд оролцогсдод 1,740.0 мянган төгрөгийн хүлээн авалт хийсэн, ЭМГ-ын даргын 2022.04.22-ны өдрийн А/20 дугаарын тушаалаар хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулахтай холбогдуулан зохион байгуулсан сургалтад оролцогч нарт 1,428.0 мянган төгрөгийн гарын бэлэг өгсөн	3,168.0	-	3,168.0	-
Төв нь юс ХХК-тай 2,400.0 мянган төгрөгөөр байгууллагын үйл ажиллагаа, зар, нэвтрүүлэг бэлтгэхээр 03 дугаартай гэрээг 2022.01.05-ны өдрийн байгуулсан байна.	2,400.0	-	-	2,400.0
Нийгмийн даатгалын улсын байцаагчийн 2022.11.10-ны өдрийн 103 дугаарын актаар тавигдсан алдангийг төсвийн хөрөнгөөр барагдуулсан	288.0	-	288.0	-
Дүн	367,687.3	900.0	49,949.2	316,838.1